

Редакторын зурвас

Эдийн засаг: Онол, практик сэтгүүлийн шинэ дугаарыг уншигч тантай хуваалцахдаа таатай байна. Зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжин орсон 10 дахь жилдээ буюу 2000 онд үүсэж, чамгүй олон жилийн уламжлалтай болсон энэ сэтгүүлээ бид 2018 оноос шат ахиулан сайжруулсаар ийнхүү 35 дахь дугаараа гаргалаа¹. Хугацааны хувьд харьцангуй хоцорч гарч буй нь 2021 оны 6-р сард “МУИС-д Эрдэм шинжилгээний сэтгүүл эрхлэн хэвлүүлэхэд баримтлах журам” батлагдаж, нэг дугаарт 5-аас дээш өгүүлэлтэй байхыг шаарддаг болсонтой холбоотой юм.

Шинэчлэгдсэн сэтгүүл маань олон улсын жишгийн дагуу, хөндлөнгийн давхар сохор шүүгчийн системээр (double-blind) бүтээлээ мэргэжлийн түвшинд хянуулах, бусад эдийн засаг сонирхогчид, шийдвэр гаргагчдад хүрэх, дэлхийн дэвжээнд гарахыг хүссэн хэн бүхэнд гүүр нь болох, дэлхийн өнцөг булан бүрд ажиллаж, амьдарч буй монгол эдийн засагчид хоорондоо танилцах, Монголынхоо хөгжилд хувь нэмрээ оруулах боломжийг олгосоор чамгүй хугацаа өнгөрчээ.

Энэхүү дугаар эдийн засгийн ухааны магистр болон түүнээс дээш зэрэгтэй хүн эдийн засгийн хичээл заана гэсэн утгатай МУИС-ийн Дүрмийн 5.6-р заалтыг баримталсныхаа төлөө МУИС-ийн Эдийн засгийн тэнхимийн эрхлэгчийн албан тушаалаас чөлөөлөгдсөн цаг үед гарж буйгаараа өвөрмөц юм². Миний бие шинээр редактор томилуулах хүсэлтээ тэнхимдээ өгөөд 4 сар өнгөрч буй ч цэвэр сайн дурын үндсэн дээр хийдэг энэ ажлын залгамжлагч маань тодроогүй байна.

Хэдийгээр барууны гэгдэх ч дэлхий нийтийн жишиг болсон орчин үеийн эдийн засгийн ухааныг Монголд нэвтрүүлэхэд маш олон хүндрэл, эсэргүүцэлтэй цаашид тулгарах ч сэтгүүл маань хүрсэн стандарт, жишгийнхээ дагуу үргэлжлэн гарах байх хэмээн гүнээ найдаж байна. Аливаа институт, технологи шинээр нэвтрэхэд хуучин нь орон зай, статусаа хамгаалах гэдэгтэй холбоотойгоор байнга эсэргүүцэл, бэрхшээлтэй тулгардаг. Ялангуяа төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг, социалист нийгмийн системтэй байсан бидний хувьд тийм хориг саад, атаархал, хорлон сүйтгэх үйл ажиллагаа нэлээд байна гэдгийг эдийн засгийн шинжлэх ухаан өөрөө сануулдаг (Varian, 1974; Hammond, 1987; Banerjee, 1990; Mui, 1995; Ofer & Polterovich, 2000).

¹ Энэ болон өмнөх дугааруудыг <http://econjournal.mn> цахим хуудаснаас үзэж болно.

² МУИС-ийн Захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн уг тушаал нь хууль зөрчсөн болохыг Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2022.04.27-ны хурлаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 167.1.2. буюу анхан шатны шүүхийн шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулах заалтын хүрээнд хянан шийдвэрлэж магадлсан болно. МУИС-ийн Захиргаа энэ талаар Дээд шүүхэд давж заалдаж байгаа.

Бид хэр их амжилтад хүрэх? “...Хуучин Зөвлөлтийн нөлөөнд байсан улсын хувьд орчин үеийн эдийн засгийн ухааныг ахисан түвшинд зааж, аналитик судалгаа хийж, эдийн засгийн бодлого боловсруулах эдийн засагчдыг үүсгэх” (Svejnar, 2000), “...Академик байгууллагуудын өмнө тулгарсан үндсэндээ хэрэггүй мэдлэгийг эдийн засгийн орчин үеийн онол болон арга зүйгээр солих шийдвэрлэх ач холбогдолтой ч асар хэцүү сорилт” (Stuart, 2000), “шинэ үеийн эдийн засагчдыг бий болгох сорилт” (Campbell, 2000)-оо бид давж чадаж байна уу? Ялангуяа эдгээр сорилтыг даван туулахад тусалж байсан өндөр хөгжилтэй улсуудын дэмжлэг зогсож, багасан “бал сар” дууссаны дараа?

Эдгээр асуултад уншигч авхай та надаас илүү хариулах биз ээ. Гэвч дараах хүснэгтэд буй мэдээлэл бид бусдаас тийм ч их дутаагүйг харуулж буй мэт. Энд Зүүн Европ, хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан болон Азийн төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн харилцаанд шилжсэн нийт 34 улсын байгалийн болон эдийн засгийн шинжлэх ухааны өнөөгийн чансааг хүн ам, эдийн засгийн үзүүлэлтүүдтэй нь харьцуулан харуулж байна. Дэлхийн 191 улсаас Монгол улс 3.3 сая хүн амтайгаар 132-т эрэмбэлэгдэж байна³. Худалдан авах чадварын паритетаар жинлэсэн Дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) хэмжээгээр Монгол 115-т эрэмбэлэгдэж байна⁴. Монголын нэг хүнд ногдох ДНБ 12317 ам. доллар болсон нь дэлхийд 103-т эрэмбэлэгдэж байна⁵.

Зохиогчийн тоогоор жинлэсэн *Web of Science*-ийн *IF-JCR* импакт фактор индекс бүхий физик, биологи, хими, математик, анагаах эм зүй, био-анагаах, инженер технологи, дэлхий-сансар судлалын олон улсын мэргэжлийн сэтгүүлүүдэд 2000-2018 онд Монголоос нийт 1662 өгүүлэл нийтлүүлсэн нь дэлхийд 116-д, нэг хүнд ногдох тоогоор 109-д эрэмбэлэгдэж байна⁶.

Харин эдийн засгийн шинжлэх ухааны судалгааны ажлын хамгийн том сан болох RePEc-ийн оноогоор Монгол 86-д, нэг хүнд ногдох оноогоор 68-д эрэмбэлэгдэж байна. Эдийн засгийн шинжлэх ухааны тэргүүлэх 68 сэтгүүлд 1990-2020 онд нийтлүүлсэн нийт өгүүллийн 4 нь МУИС-ынх байсан нь *Article Influence Score*-оор Монголыг 65-д, нэг хүнд ногдох оноогоор 53-д эрэмбэлүүлж байна⁷. Уг хугацаанд тэдгээр сэтгүүлд 107 улсын 1803 их сургуулийн л нэр гарсан байдаг. 2013-2017 онд МУИС-аас нийтлэгдсэн өгүүллүүд нь МУИС-ыг Азийн топ-100 их сургуулийн эгнээнд хялбархан багтааж байв⁸.

Орчин үеийн эдийн засгийн ухаан нь зах зээлийн эдийн засгийн суурь, дэмжлэг нь болдог учир хуучин социалист байсан улсуудын дээд боловсролын байгууллагууд хуучныг халж, орчин үеийн эдийн засгийн ухааныг заадаг, ашигладаг болох ёстой (Gur & Polterovich, 2000). Манайх шиг социалист байсан эдийн засгийг урт хугацаанд хөгжүүлэхэд орчин үеийн эдийн засгийн мэдлэгийг хуримтлуулах, дэлгэрүүлэх зайлшгүй шаардлагатай (Stuart, 2000).

Миний бодлоор орчин үеийн эдийн засгийн ухааныг Монголд нэвтрүүлэхийг эдийн засгийн бодлого, боловсрол, судалгаа хариуцсан засгийн газрын байгууллагууд маань

³ <https://data.worldbank.org/indicator/SP.POP.TOTL>

⁴ <https://data.worldbank.org/indicator/NY.GDP.MKTP.PP.CD>

⁵ <https://data.worldbank.org/indicator/NY.GDP.PCAP.PP.CD>

⁶ <https://data.worldbank.org/indicator/IP.JRN.ARTC.SC>

⁷ <https://econtop.uvt.nl>. Сэтгүүлийн онооны талаар Эрдэнэбат (2020)-оо үзнэ үү.

⁸ МУИС-ийг уг жагсаалтад байлгаж байх, байрыг нь ахиулах зорилгоор эдийн засгийн *Web of Science*-ын индекстэй сэтгүүлд бүтээлээ нийтлүүлбэл 4 сая төгрөгөөр, топ-35-д нийтлүүлбэл 7 сая төгрөгөөр Эдийн засгийн тэнхимийн төсөв, хуримтлал, эндаумент сангаас урамшуулж байх тэнхимийн шийдвэр одоогоор хэрэгжихгүй байгаа нь харамсалтай. Академик судалгаа, чанартай сургалтад чиглэсэн урамшууллын тогтолцоогүйгээр өндөр түвшний эдийн засагчдыг татан ажиллуулах боломжгүй билээ (Svejnar, 2000). Энэ талаарх дэлгэрэнгүйг Эрдэнэбат (2020)-оос уншиж болно.

**Зүүн Европ, Азийн хуучин социалист улсуудын байгалийн болон
эдийн засгийн шинжлэх ухааны чансаа**

Улс	Хүн ам		Орлого			Байгалийн ш.у.		Эдийн засгийн ш.у.-RePEc				Эдийн засгийн ш.у.-Tilburg			
(1)	(2)	(3)	(4)	(5)	(6)	(7)	(8)	(9)	(10)	(11)	(12)	(13)	(14)	(15)	(16)
1 Чех	10.7	83	45	31	41135	22	15	33	527	33	80	6	244	31	28
2 Унгар	9.8	89	54	43	31913	40	38	56	332	42	84	7	176	33	29
3 Литва	2.8	136	88	37	36376	56	34	12	42	76	57	1	18	52	37
4 Словени	2.1	145	97	35	38962	51	12	14	54	55	37	1	17	56	40
5 Эстони	1.3	151	111	38	36249	63	26	8	57	59	29	1	6	69	43
6 Хятад	1410.9	1	1	81	15497	2	52	285	1380	14	171	99	3504	8	46
7 Польш	37.9	37	20	42	31953	16	32	92	702	31	110	15	147	41	48
8 ОХУ	144.1	9	6	50	28821	12	42	181	1709	25	151	11	249	30	49
9 Монгол	3.3	132	115	103	12317	116	109	11	39	86	68	1	4	65	53
10 Румын	19.3	59	36	48	29342	34	44	108	1161	34	94	9	32	51	59
11 Гүрж	3.7	127	108	88	14596	86	77	6	27	92	76	1	4	76	60
12 Украин	44.1	31	39	102	12633	36	63	12	65	74	148	5	48	47	61
13 Азербайжан	10.1	88	75	89	14551	80	96	12	47	89	99	2	3	75	66
14 Латви	1.9	146	103	46	30877	66	37	6	37	70	41	1	1	99	67
15 Хорват	4	126	81	49	28877	47	28	14	169	65	67	1	2	90	68
16 Болгар	6.9	101	72	60	23016	53	47	30	240	64	87	1	3	87	71
17 Албани	2.8	135	117	94	13498	113	99	11	32	95	63	1	1	96	73
18 Киргиз	6.6	108	128	138	5256	128	127	5	5	141	95	1	2	93	76
19 Серб	6.9	102	80	73	17718	50	40	17	43	96	92	1	8	94	77
20 Словак	5.5	113	70	45	31215	46	31	30	146	61	79	1	4	105	85
21 Вьетнам	97.3	15	31	122	7768	58	108	58	198	53	160	3	8	67	93
22 Узбекистан	34.2	42	60	125	7253	91	149	11	37	93	146	1	3	95	98
23 Беларусь	9.4	92	69	68	19430	62	86	5	12	125	107	1	1	106	105
24 Монтенегро	0.6	163	150	63	21513	110	50	5	5	140	26	-	-	-	-
25 Хойд Македон	2.1	144	126	76	16796	92	62	14	72	85	49	-	-	-	-
26 Косово	1.8	148	146	111	11013	117	75	0	1	132	55	-	-	-	-
27 Молдав	2.6	138	127	101	12660	97	95	5	20	136	72	-	-	-	-
28 Армен	3	133	118	98	13020	83	70	4	10	128	75	-	-	-	-
29 Босни & Хер- цеговина	3.3	129	110	87	14918	88	65	11	15	114	77	-	-	-	-
30 Лаос	7.3	100	107	121	7775	135	144	2	2	162	104	-	-	-	-
31 Казахстан	18.8	62	44	56	26158	70	82	12	54	63	111	-	-	-	-
32 Камбож	16.7	68	101	146	4259	121	154	5	10	119	128	-	-	-	-
33 Тажикстан	9.5	93	130	157	3497	137	159	0	0	173	173	-	-	-	-
34 Туркменистан	6	109	95	83	15202	170	190	0	0	174	174	-	-	-	-

Багануудын тайлбар: (1)-улсын нэр, (2)-хүн амын тоо, саяар, (3)-хүн амын тоогоорх эрэмбэ, (4)-Дотоодын нийт бүтээгдэхүүнээрх (ДНБ) эрэмбэ (худалдан авах чадварын паритетаар засварласан өнөөгийн олон улсын ам. доллар), (5)-нэг хүнд ногдох ДНБ-ээрх эрэмбэ, (6)-нэг хүнд ногдох ДНБ, (7)-физик, биологи, хими, математик, био-анагаах, инженер технологи, дэлхий-сансар судлалын шинжлэх ухаан, техникийн сэтгүүлд 2000-2018 онд нийтлүүлсэн өгүүллийн тоогоорх эрэмбэ, (8)-нэг хүнд ногдох шинжлэх ухаан, техникийн сэтгүүлийн өгүүллийн тоогоорх эрэмбэ, (9)-эдийн засгийн судалгааны ажлуудын хамгийн том сан болох RePEc-д бүртгэлтэй байгууллагын тоо, (10)-RePEc-т бүртгэлтэй эдийн засагчдын тоо, (11)-RePEc-ийн улсын эрэмбэ, and (12)-нэг хүнд ногдох RePEc-ийн оноогоорх эрэмбэ, (13)-эдийн засгийн top-68 сэтгүүлд нийтлүүлсэн их сургуулийн тоо, (14)-top-68 сэтгүүлд нийтлүүлсэн өгүүллийн тоо, (15)-нийтлүүлсэн top-68 сэтгүүлийн AIS оноогоорх эрэмбэ, and (16)-нийтлүүлсэн top-68 сэтгүүлийн нэг хүнд ногдох AIS оноогоорх эрэмбэ. Улсуудыг эрэмбэлэхдээ эхлээд (16)-г, дараа нь (12)-г ашиглав. Эх сурвалж: (2)-(8)- Дэлхийн Банк (<https://data.worldbank.org>), (9)-(12)- RePEc (<https://ideas.repec.org>; 2022 оны 4-р сарын байдлаар), (13)-(16)- Тилбургийн их сургууль <https://econtop.uvt.nl>.

Хятадынх шиг хүсэж, дэмжихгүй, гадагшаа гарчихсануудыг нь эргүүлэн авч ирэхийг огтхон ч оролдохгүй байна (Chow, 2000).

Сэтгүүлийн хувьд бидний хүрсэн амжилт тийм ч муу биш мэт. Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн эдийн засагчид хамтран, эх хэлээрээ эрдэм шинжилгээний ажил хийж, үнэлүүлэх боломж олгодог өөр хэдэн хуучин социалист улс байгаа билээ? Өдгөө дайны хөлд нэрвэгдээд байгаа Украин улсын 1980 оны эдийн засгийн Нобелийн шагналтан Лауренс Клейн редакцын зөвлөлд нь байдаг байсан Украины эдийн засгийн холбооны *Ukrainian Economic Review* сэтгүүл аль дээр хаагдсан (Mirucki, 1999). Чехийн *Czech Economic Review* (<http://cer.cuni.cz/>) сэтгүүл 9 дугаар гаргаад 2016 онд хаагдсан.

Шүүгчдийнхээ оролцоогүйгээр хөндлөнгийн магадлан итгэмжлэлтэй сэтгүүлийн үйл ажиллагаа явагдах ямар ч боломжгүй билээ. Энэхүү дугаарт нийтлэгдсэн болон нийтлэхээс өмнө засаж сайжруулах шийдвэр авсан өгүүлүүдийг шүүн тунгааж, засаж сайжруулах талаар зөвлөгөө өгсөн, магадгүй дараагийн редакцын зөвлөлийг бүрдүүлэх дараах судлаачдад гүнээ талархаж байна.

- Зоригтбаатарын Чимэдлхам, Эдийн засгийн докторын оюутан, Ютагийн их сургууль, Солт Лейк, АНУ
- Даваахүүгийн Оюунбадам (Эдийн засгийн ухааны доктор, Чарлес Стюартын их сургууль, Австрали), Нээлттэй нийгэм хүрээлэн, Улаанбаатар, Монгол
- Лувсаннъямын Даваажаргал (Эдийн засгийн ухааны доктор, Австралийн үндэсний их сургууль, Австрали), Монголбанк, Улаанбаатар, Монгол
- Төмөрийн Эрдэнэчулуун (Эдийн засаг, менежментийн ухааны доктор, Вагенингений их сургууль, Нидерланд), ХААИС, Улаанбаатар, Монгол
- Гончигсумлаагийн Ганзориг (Хөдөө аж ахуйн эдийн засгийн ухааны доктор, Георг-Аугустын нэрэмжит Гёттинген их сургууль, Герман), ХААИС, Улаанбаатар, Монгол

Эдийн засгийн шинжлэх ухаан Монголд цэцэглэн хөгжих болтугай!

Гүнээ хүндэтгэсэн, Б.Эрдэнэбат

Эшлэл

- Erdenebat Bataa. 2020. Монгол эдийн засагчид болон эдийн засгийн байгууллагуудын чансаа. *Эдийн засаг: Онол, практик* 34, 2-35
- Banerjee, A.V. 1990. Envy. in Dutton *et al.* (eds.), *Economic Theory and Policy: Essays in Honour of Dipak Banerjee*, Oxford University Press.
- Campbell, R. 2000. Discussion. *Comparative Economic Studies* 42(2), 61-64.
- Chow, G.C. 2000. The Teaching of modern economics in China. *Comparative Economic Studies* 42(2), 51-60.
- Hammond, P.J., 1987, Envy, in Eatwell, J., Milgate, M. & Newman, P. (eds.), *The New Palgrave: a Dictionary of Economics*, p. 164-165.
- Mirucki, J. 1999. A visibility analysis of the scientific production of Ukrainian economists: 1969-94. *Journal of Socio-Economics* 28, 185-196
- Mui, V-L. 1995. The economics of envy. *Journal of Economic Behavior and Organization* 26, 311-336.
- Ofer, G. and Polterovich, V. 2005. Modern economics education in TEs: Technology transfer to Russia. *Comparative Economic Studies* 42(2), 5-35.
- Stuart, R.C. 2000. Introduction: Teaching modern economics in transition economies. *Comparative Economic Studies* 42(2), 1-3.
- Svejnar, J. 2000. Economics Ph.D. education in Central and Eastern Europe. *Comparative Economic Studies* 42(2), 37-50.
- Varian, H.R. 1974, Equity, envy, and efficiency, *Journal of Economic Theory* 9, 63-91.